


БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА



Ж.ГАНБОЛД

№ 10

ЗӨВШӨӨРСӨН
НЕОН ШОУ ХХК-ИЙ ЗАХИРАЛ



Ж.ДОЛЖИНСҮРЭН

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа бүтээгдэхүүн түрээслэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Энэхүү гэрээг 2015 оны 06 сарын 03-ны өдөр Нийслэлийн Биеийн Тамир Спортын Газрыг төлөөлж ахлах мэргэжилтэн Алтангэрэл овогтой Болдмаа /цаашид захиалагч гэх/, нөгөө талаас Неон шоу ХХК-ийг төлөөлж захирал Ж.Должинсүрэн нар /цаашид гүйцэтгэгч гэх / харилцан тохиролцож байгуулав.

Хоёр. Ерөнхий зүйл

- 2.1. Тус гэрээний гол зорилго нь захиалагч тал болох Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын захиалгын дагуу Улаанбаатар марафон олон улсын гүйлтийг зохион байгуулахад холбогдох харилцааг зохицуулахад оршино.

Гурав. Гэрээний хугацаа , төлбөр

- 3.1. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу дагуу явуулын тайзыг үзель, микрофон, хөгжим, өсгөгч, холбогдох тоног төхөөрөмжийн хамт, асар майхан, сандал ширээ, нээлт хаалтын краказан хаалга, хэвлэл, лед дэлгэц, тугны суурь зэргийг Улаанбаатар марафон олон улсын гүйлтийг Чингис хааны талбайд зохион байгуулахад зориулж 06 дугаар сарын 05-ны өдөр угсарч 06-ны өдрийн 19.00 цагт буулган зөөвөрлөнө.

- 3.2 Захиалагч нь гүйцэтгэлийн аль ч үед ажлын явцыг шалгах эрхтэй

3.3 Захиалагч нь тайз тоног төхөөрөмж. Асар майхан , лед дэлгэц краказан хаалга, тугны суурь ширээ сандал, хулдаасан хэвлэлхөгжим аппаратурын түрээсийн зардалд 7 585 000₮ /долоон сая таван зуун наян таван мянган төгрөгийг/ нэхэмжлэлийн дагуу төлнө.

Дөрөв . Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

4.1 Захиалагч нь ажил гүйцэтгэгчийн нийлүүлэх тоног төхөөрөмжийн тоо ширхэг загварыг гарган өгөх ба шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.

4.2. Ажил гүйцэтгэгч нь гэрээнд дурдсан ажил үүргийг тогтоосон цаг хугацаанд, хийж гүйцэтгэх үүрэгтэй.

4.3 Тайз тоног төхөөрөмжийг зөөж авч ирэх, буцаахдаа өөрсдийн машин техникээр гүйцэтгэнэ.

4.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэсний дараа тоног төхөөрөмжийг түрээслүүлсэнтэй холбогдон гарсан гэрээнд тусгагдсан үнэ хөлсийг авах

Тав. Төлбөрийн нөхцөл

5.1 Захилагч нь гүйцэтгэгчид түрээслэх техник, тоног төхөөрөмж, хэрэглэл материалыг цаг хугацаанд нь хүлээн авч ажил үйлчилгээ эхлэхээс өмнө 50 хувь тай тэнцэх дууссаны дарааүлдсэн 50 хувийн төлбөрийг ажлын 5 хоногт багтаан нэхэмлэлээр шилжүүлнэ.

Гэрээ байгуулсан

Нийслэлийн Биеийн тамир,
Спортын газрын ахлах мэргэжилтэн
А.Болдмаа

Неон шоу ХХК-ны захирал

Ж.Должинсүрэн
Рег ИЭ 82061364

2015 оны 05 дугаар сарын 03 өдөр